

# ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХӨТӨЧ НОМ



# ӨМНӨГОВЬ

## АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА МЭДЭЭЛЭЛ

1923 оны дундуур хуучин дөрвөн аймгийг өөрчлөн байгуулах Засгийн газрын шийдвэр, мөн аймгийн захиргаа байгуулах дүрмийг батлан гаргажээ. Аймаг, хошуудын газар нутгийн хэмжээ асар уудам, газрын дундыг олж төвлөж чадаагүй зэргийг харгалзан 1931 онд орон нутгийн засаг захиргааны бүтцийн өөрчлөлт хийсэн билээ. Энэ өөрчлөлтөөр урьд нь 5 аймаг, 72 хошуу, 525 сум байсныг 12 аймаг, 324 сум болгон зохион байгуулагдахад Өмнөговь аймаг шинээр байгуулагдсан байна. Ингэхдээ Богд Хан уул, Цэцэрлэг Мандлын аймгуудаас таслан зохион байгуулсан байна

Аймгийн төв: Даланзадгад хот

Хэдэн сумтай: 15

Нутаг дэвсгэрийн хэмжээ: 165,380.47 км<sup>2</sup>

Хүн ам: 69,187 (2020)

Угсаатан: Халх

Малын тоо толгой: 2,880,772 (2020)

Утасны код: +976 (0)153

Шуудангийн дугаар: 46000

ТХ-ийн улсын дугаар: ӨМ

Цахим хуудас: <http://www.omnogovi.gov.mn/>

Өмнөговь нь газар нутгийн хэмжээгээрээ Монгол улсдаа хамгийн том аймаг юм[2]. Аймгийн нутаг нь говь цөлийн мужид багтах бөгөөд дунджаар д.т.д. 1300-1600 м өндөрт оршино. Энд Алтайн нурууны үргэлжлэл Гурван сайхан, Сэврэй, Ноён богд, Номгон, Тост, Нэмэгт, Алтана уул, Гилбэнт зэрэг д.т.д. 3000 м хүртэл өндөр өргөгдсөн уул нурууд болон 100 гаруй км үргэлжилсэн Хонгорын элс, хэдэн 100 км өргөн Галба, Борзон, Зээмэг, Заг, Сүүжийн алдарт их говиуд бий.



# ДАЛАНЗАДГАД

ХОТЫН ТУХАЙ



Даланзадгад хотын үүсч хөгжсөн түүхэн замнал нь Өмнөговь аймгийн хөгжлийн үе шат бүхэнтэй хүй нэгэн холбоотой буюу говийн хангай Гурвансайхан уулын зүүн ар Далангийн дэнгжид сүндэрлэн боссон энэ хотын түүх бол Өмнөговь аймгийн түүх, нэрийн хуудас нь билээ 1931 оны намар Дэлгэрхангай уулын хошууны төвд Өмнөговь аймгийн сумдын дарга нарын семинар дээр аймгийн төвийн тухай асуудал яригдаж, хойт талын сумдын дарга нар Онгийн голын зүүн эрэг, Цогт-Овоогийн Дугшихын орчимд төвлрүүлэх, харин өмнө талын сумдынхан Даланзадгад орчимд байгуулах санал гаргажээ.

Өрхийн тоо: 8200 (2020)

Хүн амын тоо: 26,367 (2020)

Улаанбаатар хотоос алслагдсан зай: 580 км



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН

# ГАЙХАМШИГТ ГОВЬ

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБОО

Дэлхийн гарал үүслийн төв, эртний амьтан ургамал, хүн төрөлхтний өлгий нутаг, түүх соёлын үлэмж нөөц бүхий Монголын говийг дэлхий нийтэд суртачлан таниулах, Өмнөговь аймгийн аялал жуулчлалын байгууллагуудыг нэгдсэн зохион байгуулалт, зөвлөмж, чиглэл, мэдээллээр хангах зорилготой. Үйл ажиллагааны чиглэл нь Өмнөговь аймгийн аялал жуулчлалын салбарыг тогтвортой аялал жуулчлалын загвар болгон хөгжүүлэх, байгаль орчин, экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх түшиц хүчин болон ажиллах, аялал жуулчлалаас малчид, иргэдийн олох ашиг орлогыг нэмэгдүүлэх, тэдний хөгжлийг дэмжих, аялал жуулчлалын үйлчилгээ, үйл ажиллагаа байгаль орчныг хамгаалах, бүх нийтэд экологийн боловсрол олгох сургалт, семинарыг зохион байгуулах болон нишүүн байгууллага, иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах зэрэг юм.

Байгуулагдсан он: 2008

Тэргүүн: Х.Түмэндэлгэр

Гишүүдийн тоо: 11

# ӨМНӨГОВЬ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МАРШРУТУУД

## Гайхамшигт Галба нутгийн аялалын маршрут

*/Өмнөговь аймгийн Ханбогд сумын байгалийн үзэсгэлэнт газруудаар аялах аялал/*

### **Чиглэл нь:**

Даланзадгад – Цагаан хад - Хүрдэт агуй – Мангасын хүрээ – Гурван Зээрдийн агуй – Ханбогд хайрхан – Баяжихын агуй – Дэмчигийн хийд, Энергийн төв – Ханбогд сум – Өрөлбө - Байшинт цав – Шар цав – Загастай чулуу – Мянган хайлаастай гол – Манлай сум - Даланзадгад

## Хэрмэн цав чиглэлийн маршрут

*/Говь нутгийн иргэдийн уламжлалт ёс заншил, нүүдэлчин соёл болон байгалийн уран сонин тогтоц, элсэн манхан, зэрлэг ан амьтан, шувууд, ургамал бүхий баян бүрдтэй эко аялал/*

### **Чиглэл нь:**

Даланзадгад – Ёлын ам – Дүнгэнээгийн ам – Баяндалай сум – Ноён сум – Сарын хөндий – Гурван Тэс сум – Наран даац баянбүрд – Хэрмэн цав – Зуун мод зулганайн баянбүрд – Нэмэгтийн их хонгил – Ухаа толгод – Сэврэйн хадны сүг зураг - Сэврэй сум – Хонгорын элсэн манхан, Хонгорын гол баянбүрд – Булган сум - Баянзаг – Даланзадгад

## Хонгорын гол, Баянзагийн чиглэлийн аяллын маршрут

*/Говь нутгийн иргэдийн уламжлалт ёс заншил, нүүдэлчин соёл болон байгалийн уран сонин тогтоц, элсэн манхан, зэрлэг ан амьтан, шувууд, ургамал бүхий баян бүрдтэй эко аялал/*

### **Чиглэл нь:**

Даланзадгад хот – Ёлын ам – Дүнгэнээгийн ам – Баяндалай сум – Хонгорын элсэн манхан, Хонгорын гол баянбүрд – Хавцгайтын хадны сүг зураг - Булган сум - Баянзаг – Молцог элс - Даланзадгад хааны цэргийн хотын үлдэгдэл - Ширээт нуур - Арвайхээр

## Ёлын ам, Баянзаг чиглэлийн аяллын маршрут

*/Говь нутгийн иргэдийн уламжлалт ёс заншил, нүүдэлчин соёл болон байгалийн уран сонин тогтоц, элсэн манхан, зэрлэг ан амьтан, шувууд, ургамал бүхий баян бүрдтэй эко аялал/*

### **Чиглэл нь:**

Даланзадгад хот – Ёлын ам – Хавцгайтын хадны сүг зураг – Булган сум – Баянзаг – Молцог элс – Даланзадгад хотБат-Өлзий сум – Улаанцутгалан - Төвхөн хийд - Баруун хүрээ - Эрдэнэзуу хийд - Хөгнө тарнийн хийд

# ҮЗМЭРҮҮД

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **ХОНГОРЫН ЭЛС**

Өмнөговь аймагт элсэн нуруу, манхан, тармаг элс аймгийн бүх нутгийн 3 орчим хувийг эзэлдэг. Үүний дотор Сэврэй, Номгон, Зөөлөн уулийн ар хоолойг дагаж баруунаас зүүн тийш 185 км үргэлжлэн 925 ам дөрвөлжин км талбай эзлэх Хонгорын элс хамгийн том бөгөөд Монгол улсын томоохон баянбүрдийн нэгэнд тооцогдох юм. Хонгорын элсний баруун үзүүрт орших баруун зүүн Шургуул, Тал гашуун, Адаг гашуун, Талын цүнхэл, Хоохорын тээг, Хун нуурын шал, Харын боом, Шар хулсан зэрэг хиаг, хулсширэг, заг, сондуул, хужир бүхий сонин тогтоцтой хонхор хотгор газар юм. Элсэн манхан нь ёроолоосоо дээд оргил хүртэл 10-195 метр хүртэл цавчим өндөр бөгөөд салхитай үед янз бүрийн хөгжим эгшиглэх мэт дуу авиа гардаг. Үүний тод жишээ нь Хонгорын голын дуут манхан юм. Энэ нь салхинд элсний маш нарийн ширхэгүүд хийсч сарнин цахилгаанжаад түүний эерэг сөрөг цахилгаан цэнэг үрэлдсэнээс ийнхүү чимээ гардаг байна. Хонгорын элс нь шовх оройтой үргэлжилсэн алтан шаргал уул бий болгож ар ёроолоосоо урсгал булаг, ногоон зүлэгтэй, түүний хөвөөгөөр мал сүрэг налайн бэлчиж адаг цагаан нууранд нь усны шувууд ганганалдан чухам нүдийг хужирласан нутаг юм. 2010 онд Монголын говь нэрээр аймгаа төлөөлөн “Монгол улсын есөн гайхамшиг”-аар тодорсон.



# ҮЗМЭРҮҮД

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **БАЯНЗАГ**

Баянзаг нь Монголын цаашлаад дэлхийн байгалийн түүх, археологи, шинжлэх ухааны нэн чухал дурсгал, ул мөр олдворуудыг харьцангуй сайнаар хадгалах үлдсэн алдарт Арц богдын уулсын дагуух уудам хөндийд оршихбөгөөд Баянзагаас өнөөг хүртэл хүн төрөлхтөний эртний түүх, археологи палентологын нэн чухал, ховор олдворууд олдсоор байгаа түүхэн чухал газар орон юм. Иймээс Тонгол орон төдийгүй дэлхий нийтэд алдаршсан нэн чухал газар нутгийнх нь хувьд “Баянзаг – Flaming Cliffs” –ийг 2010 онд Монголын говь нэрээр аймгаа төлөөлөн “Монгол улсын есөн гайхамшиг”-аар тодорсон. Баянзаг нь амьтан ургамлын түүхэнд чухал байр суурь эзлэх, нэгэн үеийн томоохон төлөөлөгч болох, одоогоос 60-100 са жилийн өмнө амьдарч байсан үлэг гүрвэлийн томоохон нээлт болсон юм.Эндээс дэлхийд хамгийн анхны доторхи хөврөл нь дөнгөж гараад царцаж үлдсэн үлэг гүрвэлийн өндөгнүүд олдсон нь дэлхийн шинжлэх ухааны түүхэнд томоохон нээлт болсон юм. Дэлхийн байгалийн долоон гайхамшигт нэр дэвшиж буй Өмнөговь аймгийн Булган сумын нутагт орших “ Улаан эрэг” гэдэг нэрээрээ илүү алдаршсан газар. Энэхүү газарт 1920-иод онуудад Америкийн Байгалийн түүхийн музейн зохион байгуулсан Төв Азийн экспедицийг ахлан тус нутагт ирсэн палеонтологич Рой Чэпмен Эндрюс хадан хясааны тод улбар өнгөөр Улаан эрэг хэмээн нэрлэжээ. Уг өнгө нь ялангуяа нар жаргах үед онцгой тодордог.



*Photo by Bayar*

# ҮЗМЭРҮҮД

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### ГОВЬ ГУРВАН САЙХАН

Ёлын ам нь аймгийн төвөөс баруун тийш 56 км-т Зүүнсайхан ууланд байрлалтай Говь гурвансайханы байгалийн цогцолборт газрын аялал жуулчлалын бүсэд багтдаг байгалийн үзэсгэлэнтэй газар нутаг юм. Ёлын амыг 1965 онд дархан цаазат газар болгох АИХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол гарснаар Говийн экосистемийг хамгаалах асуудлын үндэс тавигдсан бөгөөд 1993 онд Ёлын амны дархан цаазат газрыг өргөжүүлж, 1993 онд ГГСБЦГ болгосон. Уулсын дундаж өндөр 2200-2600 м. Тэдгээр нь цэрдийн галавын хурдацнаас тогтсон, эвдрэл, элэгдлийн хэвгий гадарга бүхий өргөн бэлээр хүрээлэгдсэн байдаг. Энд эх газрын хуурай, ширүүн, эрс тэс уур амьсгал зонхилно. Зундаа дунджаар 39 хэмийн дулаан, өвөлдөө 25-35 хэмийн хүйтэн, жилд унах хур тунадасны хэмжээ зарим газартаа 50 мм-ээс бага байдаг нь Төв Азийн хамгийн хуурай уур амьсгалтай газрын нэгэнд зүй ёсоор ордог. Ёлын ам нь Говь Гурван Сайхан уулын ам бөгөөд ёл шувуу ихтэй болохоор ийм нэр авчээ. Далайн төвшнөөс дээш дунджаар 2800 метр өндөр. Дархалсан талбай нь 64 ам километр. Зүүнсайхан уулыг зүүн хойшоо сэтлэн урссан голын нарийхан хавцал юм. Хавцлын голоор жижиг горхи урсдаг бөгөөд өвөл мөсөн бүрхүүлээр хучигддаг. Жилийн турш мөстэй байдаг байсан боловч сүүлийн жилүүдэд дэлхийн дулаарал зэргээс шалтгаалан ихэнх хэсгийн мөс нь хайлдаг болсон.



Photo by Bayar



# ҮЗМЭРҮҮД

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **НЭМЭГТ, ХЭРМЭН ЦАВ**

Хэрмэн цав: Гурван тэс сумаас баруун хойш Тостын уулын ар хоолойд сумаас 150 км-т орших маш үзэсгэлэнтэй хайлаас, тоорой, сухай бүхий баянбүрдтэй мөн палендлогын ховор олдворт дээд цэрдийн хурдасаас тогтсон газар нутаг юм. Энэ газар нутгаас Теризинозавар, забролож, тарбазабр, эвэрт үлэг гүрвэл, пинакозабр гэх мэт үлэг гүрвэлийн яс олдсон. Энэ газар нутгаас Теризинозавар, забролож, тарбазабр, эвэрт үлэг гүрвэл, пинакозабр гэх мэт үлэг гүрвэлийн яс олдсон. Зулагнайн гол: Алтан уулын баруун суганд орших Талын хайрганы адгаас эх авсан үзэсгэлэнт баянбүрд юм. Голын голдиролд зэгс, сухай, чихэр өвс элбэг ургана. Заг товцог, жигд, тоорой, хайлаас зэрэг элсэн манхануудаар хүрээлэдсэн байгалийн үзэсгэлэнт газар юм. Нэмэгт уул, Алтан уул, Төгрөгийн ширээ, Ухаа толгод, Хэрмэн цав зэрэг газрууд нь үлэг гүрвэлийн олдвороор дэлхийн палеонтологийн салбарт танигдсан газрууд төдийгүй олон улсын шинжилгээний ангиуд байнга судалгаа хийж байдаг билээ. Нэмэгт уулын тэгш өндөрлөг дээрээс эцэс төгсгөлгүй үргэлжлэх олон хавцлыг харах боломжтой. Нэмэгт уулын гол хавцал нь гурав салаалдаг бөгөөд тэнд очиход ер бусын үлгэр домгийн ертөнцөд очсон мэт санагддаг. Он цагийн аясаар элэгдсэн хананууд нь янз бүрийн цонх, тагттай байшинг санагдуулахаар харагдана. Тэрхүү хананд үлэг гүрвэлийн яснууд цухуйн харагдах нь гайхамшигтай.




Photo by Bayar

# ҮЗМЭРҮҮД

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **НОЁН БОГД, ТОЛЬ ХАД**

Толь хад, Саран хөндий, Гурван түшмэл, Ханын хэц, Цагаан ханын агуй гэх мэт Ноён сумын нутагт орших байгалийн үзэсгэлэнт газрууд орно. Аймгийн төвөөс 200 гаруй километрийн зайд орших Гурван тэс сумын Баясах баг орчим, Ноён сумын Толь хад, Сарын хөндийн орчмын нийт 32 мянга орчим га газрыг орон нутгийн тусгай хамгаалалад авсан. Учир нь тус бүс нутагт байгалийн үзэсгэлэнт Толь хад зэрэг газар байдаг. Өмнөговь аймгийн нутаг Дүгнэн уулын ард 10 м гаруй урт, 3 м орчим өндөр Толь хад гэдэг том цохио бий нь хүн амьтны дүрс тод харагдам гялгар өнгөтэй юм. Эрт галавт уул цогцлон тогтох хөдөлгөөнөөр том цохио чулуу, өнхөрч гулсан бусад чулуулагтай хавирч үрэлдсэнээс ийнхүү гялалзсан толь шиг болсон гэж судлаачид үздэг. Дуут манхны урдуур нь дүнхийх Хатан Сэврэй уул эмэгтэйчүүдийг ивээдэг хэмээн нутгийнхан шүтэж ирсэн домогтой тул “хатан” хэмээх өргөмжлөлтэй болжээ. Сэврэй сумтай хил залгаа Ноён сумын Толь хад, Ноён богд уул, Хатан Сэврэй, Хонгорын элс дөрвийн тухай ийм нэгэн домог бий. Эрт цагт нутгийн нэгэн ноён ааш муутайгаараа алдартай Сэврэй хэмээх эхнэрээ хашраахын тулд түшмэлийнхээ зааснаар хатнаа алс газар цөлөх болжээ. Уурлаж бухимдсан Сэврэй хатан ноёны цэргүүдээр харгалзуулан алс газар явах замдаа толио шидэж орхитол толь нь олон хэсэгт бутран хагарсны нэг нь Толь хадыг үүсгэсэн гэдэг



# ҮЗМЭРҮҮД

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### ГАЛБЫН ГОВЬ

Манай улсад алдартай 33 говь бий. Үүнээс хамгийн том нь улаан хүрэн тэмээгээрээ алдартай “Галбын говь” ажээ. Монголын зүүн өмнөд говийн үндсэн шинжийг төлөөлсөн байгалийн унаган төрхөө харьцангуй сайн хадгалсан дэлхийд ховор хулан, хар сүүлт, аргаль янгирын гол байршил нутаг бөгөөд Монголын жинхэнэ говийн байгалийн иж бүрдэл, газарзүйн өвөрмөц төрхийг хамгаалах зорилгоор 1996 онд УИХ-ын 43 дугаар тогтоолоор дархлан хамгаалж улсын тусгай хамгаалалтанд авсан. Галбын гурван хийд, Ханбогд хайрхан, Ундайн гол, Хөдөлдөг цохио, Ловон чомбын агуй, Мэлхий цохио, Гурван зээрдийн агуй, Шар цавын үлэг гүрвэлийн мөр зэрэг Ханбогд, Манлай сумын нутагт орших нутгууд орно. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутгийг хамрах бөгөөд Монгол орны алдарт 33 говийн дотор хамгийн том нь юм. Галбын улаан хүрэн тэмээдээрээ алдартай нутаг билээ. Нутгийнхан “ганган улаан тэмээ” хэмээн нэрлэдэг. Галбын говийн унаган төрх аль хэдийнэ алдагдаж, Оюутолгойн ордыг түшиглэн суурин газрын шинжтэй болж өөрчлөгдөн Галбын говийн алтарсан сайхан улаан шаргал өнгө нь аль хэдийнэ гундаж эхэлжээ. Галбын говийн нийт талбай нь 70 мянган хавтгай дөрвөлжин километр, урт нь 200 километр, өргөн нь 50 гаруй километр газрыг хамарна. Нарны гэрэлд алтан шаргал өнгөтэй харагддаг бол нар жаргах үед хүрэн улаан өнгөтэй болж өөрчлөгдөнө.



# ҮЗМЭРҮҮД

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **САНГИЙН ДАЛАЙ ХИЙД**

1707 онд Үйзэнсаарав гэлэнгийн суурийг тавьсан 1772, 1835 онуудад баригдсан Чогчин сүм, Дүйнхэр дуган зэрэг 9-н гол дугантай, 70:90 метр хэмжээтэй хөх тоосгон хэрэмтэй энэхүү хийд нь тухайн үедээ Монголын говь дахь томоохон хийдийн нэг байсан бөгөөд манай аймагт өнөөг хүртэл бүрэн бүтэн хадгалагдан үлдсэн цорын ганц хийд юм. Өмнөговь аймгийн Номгон сумын нутагт 1707 онд Тал хүйтний хөндий хэмээх газарт байгуулагджээ. Түвдээс ирсэн бадарчин лам "Үйзэн Саарав" гэдэг булгийн дэргэд буудаллаж сан тавьж, ард талд нь жижиг шавар байшин бариулснаар эхлэл нь тавигдсан гэдэг. Түвдээс ирсэн бадарчин лам Үйзэн Саарав нэгэн булгийн дэргэд буудаллаж сан тавьж, ардхан талд нь жижиг шавар байшин бариулснаар эхлэл нь тавигджээ. 1708 оноос лам хувраг сууж эхлэн 1772 онд цогчин дуган барьж, Энх-Амгалангийн хаалга хийлгэж "Рашчойнхор дамбадаржаалин" хийд хэмээн нэрийдэх болжээ. 1835 оноос үйл ажиллагаа нь улам өргөжин Дүйнхорын дуган, Хайлан дуган, Жүдийн дуган, Сахиусны дуган, Гүүргийн дуган зэргийг барьж, ном судар барлаж хэвлэх, мамба жүд зэрэг төрөлжсөн сургалтын дацангууд байгуулжээ. Сангийн далай хийд нь хааш хаашаа 98 метр орчим хэрмэн хашаатай, 500 гаруй лам хуврагтай, 11 дуган сүмтэй, 8 дацан, 10 жастай, 11 мянган малтай, 1500 гаруй сүсэгтэн шавьтай болтлоо өргөжсөн байжээ



# БУСАД ҮЗМЭРҮҮД



## МУХАР ШИВЭРТИЙН АМ

Энэ газар нь Говь гурван сайхан ууланд байдаг. Зуны халуунд ч мөстэй хэвээр байж гадна дотноос ирэх зочид гийчдийн анхаарлын төвд байдаг байгалийн үзэсгэлэнт газар юм. Та бүхний харж байгаа шиг хавцлын өндрөөс урссан ус нь мөс болон хөлдсөн уулын амны мухарт орших ам юм. Энд ан амьтны дүрс бүхий хад цохио, анхилам үнэрт арцнаас гадна аагтай амттай зэрлэг сонгино, тошлой, ан амьтан, жигүүртэн гээд үзэж сонирхох зүйл их. 10 гаруй метрийн өндөр хаднаас урсах горхи хүрхрээг санагдуулна. Өвөлдөө хуримтлагдаж хөлдсөн мөс 7 дугаар сарын сүүл хүртэл хайлж амьждаггүй.

## ДЭМЧИГИЙН ХИЙД

Өмнөговь аймгийн Ханбогд сумаас 11 км-ийн зайд Дэмчогийн хийд оршдог. Уг хийдэд улааны шашны тэргүүн шүтээн Ловон Бадамжунай бурхныг залан байрлуулсан байдаг билээ. Дэмчогийн хийдийг говийн догшин ноён хутагт Данзанравжаа байгуулж, номын өргөөгөө байгуулж байсан түүхтэй аж. Ноён хутагт 1830 онд 27 насандаа эл нутагт морилон очиж, “Энэ нутаг миний хувьд бууж мордоод өнгөрөх төдий бус амьдралынхаа тодорхой хэсгийг өнгөрөөх ёстой нутаг орон байна” хэмээн айлдсан гэнэ. Учир нь эл нутагт хүний шиднээс илүү газрын шид нь ноёлсон, хүн шүтэж биширч чадвал сайн сайхан бүхнийг хүнд өгч чадах, галав юүлэх, ертөнц мөхөх тэр хэцүү цагт цөөн хэдэн хүний амийг аваад үлдэх ер бусын газар орон байна хэмээн хутагт айлдаж байсан түүхтэй ажээ. Тиймээс ноён хутагт амьдралынхаа 20 гаруй жилийг эл нутагт өнгөрөөж, Дэмчогийн хийд, Эрээтийн хийд, Цагаан толгойн хийд гэсэн гурван холбоо хийд байгуулсан байна. Говийн ноён Хутагт Данзанравжаагийн эргэл мөргөлөө хийж, номын айлтгалаа үйлдсэн энэхүү хийдийг дээрээс харахад вааранд суулгасан цэцгийн хэлбэртэй байгуулсан байдаг. Хийдийн ар талд байрлах бэлэг хэдийг ноён хутагт өдрийн турш аравнайлан арц, хүж уугуулан, рашааны дээжээ өргөн өнжсөн гэдэг.

## НЭМЭГТИЙН ИХ ХОНГИЛ

Өмнөговь аймгийн Гурвантэс сумаас хойш 60 км, аймгийн төвөөс 320 км зайд орших, есөн гайхамшгийн нэг, аймгийн нутаг дэвсгэрийн баруун хэсгийн хамгийн өндөр уулсын нэг бол Нэмэгт уул юм. Энэхүү уул нь далайн түвшнээс дээш 2769 м өргөгдсөн. Баянзагтай адил улаан шаварлаг хурдсуудаас тогтсон, уулархаг учраас нэн сүрлэг өвөрмөц дүр төрхтэй байдаг. Нэмэгт уул, Алтан уул, Төгрөгийн ширээ, Ухаа толгод, Хэрмэн цав зэрэг газрууд нь үлэг гүрвэлийн олдвороор дэлхийн палеонтологийн салбарт танигдсан газрууд төдийгүй олон улсын шинжилгээний ангиуд байнга судалгаа хийж байдаг билээ. Нэмэгт уулын тэгш өндөрлөг дээрээс эцэс төгсгөлгүй үргэлжлэх олон хавцлыг харах боломжтой. Уулын гол хавцал нь гурав салаалдаг бөгөөд тэнд очиход ер бусын үлгэр домгийн ертөнцөд очсон мэт санагддаг.



# БУСАД ҮЗМЭРҮҮД


## ТОСТ ТОСОН БУМБЫН НУРУУ

Гурван тэс сумаас баруун хойш 45 км-т орших Тост Тосон бумбын ууланд ирвэс хамгаалах “Ирвэс” төв ажилладаг. Тус уул нь далайн төвшнөөс дээш 2517 метрийн өндөртэй, эгц цавчим оргил, нуруудтай, Цоохор ирвэс болон түүний гол идэш тэжээл болох Янгир ямааны гол тархац нутаг бөгөөд одоогоор 800 орчим янгир ямаа байгаа гэж тооцож байна. Цоохор Ирвэсийн баасанд хийсэн шинжилгээгээр идэш тэжээлийн 64 хувь нь нгир байгааг тогтоосон байдаг. Цоохор Ирвэс тогтвортой амьдарч байна. Ирвэс төвийнхөн өнгөрсөн хугацаанд 15 ирвэсийг хүзүүвчилж судалгаагаа явуулж байна. Тост ууланд говийн бусад уул нуруудын адил ургамлын бүрхэвч, амьтад шувууд бий. 2012 онд Ирвэс төвөөс санаачлан Тост уул түүний орчныг Улсын тусгай хамгаалалтад авах санал ирүүлснийг Гурван тэс сумын ИТХурал, Өмнөговь аймгийн ИТХурлаас дэмжсэн тогтоол гаргасан юм.



## ШАР ЦАВ

Аварга биет Зауролоф аймшигт махчин Тарбозавр гэх мэт Монголчуудын домоглон ярьдагаар аварга “Луунууд” болох эртний үлэг гүрвэлийн 5-6 зүйлийн 18000 мөрийг өдий хүртэл хадгалж ирсэн саяхан болтол хэний ч мэдээгүй байсан “Шар цав” хэмээх газар нь Манлай, Ханбогд сумын зааг нутагт байрладаг. Анх 1995 онд Палеонтологи, геологийн хүрээлэнгийн захирал, доктор Х.Цогтбаатарын ахласан Монгол-Японы судалгааны баг нээсэн юм. Өмнөговь аймгийн Манлай сумын нутагт байдаг Шар цав гэдэг газраас үлэг гүрвэлийн мөр анх олсон юм. Хээрийн судалгааны ажил дуусч байсан учраас нарийн судалгаа хийгдээгүй. 1996 онд нарийн судалгаа хийж, дөрөв, таван удаа хээрийн судалгааны анги энэ нутагт ажилласан. Энэ үнэхээр үлэг гүрвэлийн мөрт газар мөн байна. Дэлхий дээр олддог бусад мөрт газраас маш их онцлогтой ховор сонин. Нэг дор маш олон төрлийн үлэг гүрвэл гүйгээд явж өнгөрсөн мөрнүүд хадгалагдсан гэдэг нь тогтоогдсон. Түүгээр ч барахгүй мөрт үе давхаргаас тун холгүй үлэг гүрвэлийн чулуужсан яс олдсон юм.



## ОНГИЙН УЛААН НУУР

Говийн нийт нутаг дэвсгэрт гадаргын усны нөөц харьцангуй бага. Гэвч хангайн нуруунаас эх аван 400 гаруй км урсаж Булган, Мандал-Овоо сумын нутагт оршдог, Онгийн Улаан нууранд цутгадаг Онгийн гол нь Монгол орны цөөхөн “Эх оронч гол”-ын нэг юм. Улаан нуур нь дээр үед уртаараа 45 км, өргөнөөрөө 40 км, зарим газраа 11-15 м гүн, говийн хамгийн том 5 нууруудын нэг байсан. Эртнээс нааш говийн таван нуурын гэж нэрлэгдсэн Баянхонгор аймгийн Бөөн цагаан, Орог, Адгийн цагаан, Таацын цагаан, Улаан нуураас одоогийн байдлаар Бөөн цагаан, Орог, Улаан нуурууд сэргэж эхлээд байна. Говийн экосистемд ялангуяа Монгол орны нутагт дэвсгэрээр дамжин нүүдэг нүүдлийн шувуудын хамгийн гол түшиц нуур юм. Улаан нуур нь 1990 оноос явагдсан “Алт” хөтөлбөрт хамгийн ихээр өртөж 1997 онд бүрэн хатаж ширгэсэн билээ.



# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУД

## ХОНГОРЫН ЭЛС ОРЧМЫН БААЗУУД




### ГОВЬ ЭРДЭНЭ

📍 Өмнөговь аймгийн  
Сэврэй сум

☎ 99822008  
98986038

🌐 [facebook.com/gurvanerdenecamp](https://facebook.com/gurvanerdenecamp)

📄 [lounge.resistors.showroom](https://lounge.resistors.showroom)  
43°49'19.8"N 102°19'53.4"E



### ЖУУЛЧИН ГОВЬ-2

📍 Өмнөговь аймгийн  
Сэврэй сум

☎ 96658704  
88113389

🌐 [facebook.com/juulchingobicamp](https://facebook.com/juulchingobicamp)

📄 [lounge.resistors.showroom](https://lounge.resistors.showroom)  
43°47'52.1"N 102°16'15.5"E



### ГОВЬ ДЕСКОВЕРИ ТУР-2

📍 Өмнөговь аймгийн  
Сэврэй сум

☎ 98387299  
88601368

🌐 [facebook.com/gobidiscoverycamp/](https://facebook.com/gobidiscoverycamp/)

📄 [lounge.resistors.showroom](https://lounge.resistors.showroom)  
43°46'30.5"N 102°20'15.3"E

# ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУД



## ДАЛАНЗАДГАД ХОТЫН ЗООГИЙН ГАЗРУУД




### ХИШИГ РЕСТОРАН

Өмнөговь аймгийн  
Даланзадгад хот

70530909

Монгол, Европ, Ази хоол, хүргэлт  
<https://www.facebook.com/glmt.umnugovi/>

lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



### ГОБИ СЭНДС

Өмнөговь аймгийн  
Даланзадгад хот

70530024

Монгол, Европ хоол  
<https://www.facebook.com/Gobisands/>

lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



### ЭРХЭС

Өмнөговь аймгийн  
Даланзадгад хот

89699206  
99059206

Пицца, Монгол хоол  
[www.facebook.com/Эрхэс-төв](http://www.facebook.com/Эрхэс-төв)

lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



# ЭВЭНТ БАЯР НААДМУУД

## САРЛАГИЙН БАЯР

Сарлагийн баярыг анх 2012 оноос эхлэн зохион байгуулсан. Сарлагийн баяр арга хэмжээ нь Зүүн Сайхан ууланд орших Ёлын аманд жил бүрийн 05 дугаар сарын 4 дэхь долоо хоногийн бямба гаригт зохион байгуулдаг.

### ХУГАЦАА:

Жил бүрийн 5 сарын 04 дэхь долоо хоногийн бямба гарагт

### ХААНА:

Өмнөговь аймаг, Баяндалай сум, Ёлын ам

### ХӨТӨЛБӨР:

Сарлагийн баяраар сарлагийн сүү цагаан идээ, саваг, ноолуураар хийсэн бүтээгдэхүүний худалдаа, сарлагийн уралдаан, сарлаг бугуйлдаж барих, ноослох, унаж сургах тэмцээн, сарлаг үхрийн маллагааны уламжлалт хэрэгсэл дүүгүүрийн хол шидэх, бай оноох тэмцээн болдог.



## ТҮМЭН ТЭМЭЭНИЙ БАЯР

Дэлхийд ховорхон хоёр бөхт тэмээн сүргийг хайрлан хамгаалах, тэмээнд олон нийтийн анхаарлыг хандуулах, тэмээчин ардын хөдөлмөрийг үнэлэх, тэмээний амьдын үнэлэмжийг нэмэгдүүлэх, аялал жуулчлалаас ард иргэдийн ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилготойгоор жил бүр Түмэн тэмээний баярыг зохион байгуулж ирсэн түүхтэй билээ.

### ХУГАЦАА:

Жил бүрийн 3 сарын 5, 6, 7

### ХААНА:

Өмнөговь аймаг, Булган сум

### ХӨТӨЛБӨР:

Тэмээтэй парад жагсаал, тэмээтэй сайхан хос, тэмээн поло, сурагчдын урлагын тоглолт, гар урлалын үзэсгэлэн худалдаа, тэмээний уралдаан, торомны уралдаан, шагайн харваа, тэмээтэй буухиа тэмцээн зэрэг сонирхолтой, хөгжилтэй уралдаан тэмцээн үзүүлбэрүүд явагддаг.



# ЭВЭНТ БАЯР НААДМУУД

## ИНГЭНИЙ СҮҮНИЙ БАЯР

Жил бүрийн өвлийн адаг сарын шинийн 15-нд, Цагаан сарын өмнө болдог. Өмнөговь аймгийн брэнд бүтээгдэхүүн Ингэний сүү цагаан идээг сурталчлан борлуулах зорилготой.

### ХУГАЦАА:

Жил бүрийн 1 сарын сүүлээр

### ХААНА:

Өмнөговь аймаг, Даланзадгад сум

### ХӨТӨЛБӨР:

- Олны таашаалд нийцсэн бүтээгдэхүүн
- Шилдэг тэмээний ноосон гар урлалын бүтээгдэхүүн
- сүү цагаан идээ, тэмээний ноосон бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа



## ЭЛСЭН МАНХНЫ БАЯР

Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх хүрээнд, говь нутгийн байгалийн өвөрмөц тогтоц, байгалийн сайхныг нийтэд сурталчлах, гадаад дотоод жуулчдын аялах хугацааг уртасгах, эртний үлэг гүрвэл, эрэлхэг баатар, домогт хатадууд болон говийн домгоор элсэн урлал бүтээх зорилгоор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор жил бүрийн есдүгээр сарын хоёрдахь 7 хоногийн амралтын өдрүүдэд "Элсэн манхны баяр" арга хэмжээг зохион байгуулдаг билээ.

### ХУГАЦАА:

Жил бүрийн 9 сарын 2 дахь долоо хоногийн бямба, ням гарагт

### ХААНА:

Сэврэй сум, Дуут манхан

### ХӨТӨЛБӨР:

Элсний марафон, элсний оргил булаалдах тэмцээн, элсний воллейбол, элсэн урлалын баримал зэрэг уралдаан тэмцээнүүд болдог үзэсгэлэн худалдаа, тэмээний уралдаан, торомны уралдаан, шагайн харваа,





# ӨМНӨГОВЬ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МАРШРУТ



ДАЛАНЗАДГАД - ХЭРМЭН ЦАВ - ДАЛАНЗАДГАД

1100 км



## ДАЛАНЗАДГАД-ХЭРМЭНЦАВ АЯЛЛЫН МАРШРУТ